

**БАТЛАВ : СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ**



**/О.АЛТАНБААТАР/**

**Огноо: 2024 оны 03 сарын 05**

**“ЕБС-ИЙН ҮДИЙН ЦАЙ”-НЫ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ**

**ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Тендер шалгаруулалтын гэрээний нэр:**

**“ЕБС-ИЙН ҮДИЙН ЦАЙ”**

**Тендер шалгаруулалтын гэрээний дугаар:**

**ХЭАДСЕБС/20240202002**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2024.03.05

Тендер шалгаруулалтын дугаар: ХЭАДСЕБС/20240202002

*ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ* нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос *ҮДИЙН ЦАЙНЫ ХООЛ ХҮНСНИЙ МАТЕРИАЛ*-ийг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна

Тендерийн баримт бичгийг, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр Тендерийн материалыг Цахим тендер зохион байгуулалт, журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 /тавин мянган/ төгрөгийг төлнө. Үнийн санал ирүүлэх материалын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2024 оны 03 дүгээр сарын 15-ний өдрийн 10 цаг 00 минут-аас өмнө Цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2024 оны 03 дүгээр сарын 15-ний өдрийн 10 цаг 30 минутанд Дархан сумын ЕБС-ийн 2 давхар 211 тоот өрөөнд нээнэ.

Дотоодын давуу эрх Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хэнтий аймаг, Дархан сум, 4-р баг ЕБС-ийн  
Захирал О.Алтанбаатар, Нийгмийн ажилтан Н.Цэрэнжав  
Утас: 93333383, 98907109

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

**1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа** 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.

**2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт** 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.  
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг 2.3. хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.

**3. Тендерийн иж бүрдэл** 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд: (а) Үнийн санал;  
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;  
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/  
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;  
(д) Оролцогчийн ирүүлэх бусад тендерийн бичиг баримт нь тендер шалгаруулалтын өгөгдөлийн хүснэгт, захиалагчаас өгсөн техникийн тодорхойлолтод заасан материалуудыг бүрдүүлсэн байна.

**4. Тогтмол үнэ** 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана.

**5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд** 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.  
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

**6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа** 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

**7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх** 7.1.

**8. Гэрээ байгуулах  
эрх олгох тухай  
мэдэгдэл**

- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Хүнсний бараа бүтээгдэхүүн худалдаалах тусгай зөвшөөрөлтэй байх \ нотариатаар баталгаажуулсан байх \</li> <li>2. Улсын бүртгэлийн гэрчилгээ/ нотариатаар баталгаажуулсан байх</li> <li>3. Шүүхийн тодорхойлолт</li> <li>4. Харилцагч банкны хугацаа хэтэрсэн өр зээлгүй тухай тодорхойлолт</li> <li>5. Нийгмийн даатгал, татварын өргүй байх тодорхойлолт</li> <li>6. Байгууллагын санхүүгийн тайлан /сүүлийн 2 жил хүртэлх /</li> <li>7. Сүүлийн [2]жил хүртлэх энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан түүнийг чанартай сайн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт, хэрэв байхгүй тохиолдолд тухайн ААН- ийн тодорхойлолт /Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах бүрэн чадвартайг батлах/</li> <li>8. Тендерийн үнийн саналд хувилбарт үнийн санал ирүүлэхгүй байх.</li> <li>9. Хавсралтаар өгөгдсөн техникийн тодорхойлолтыг хүлээн зөвшөөрч мөрдлөгө болгоно</li> </ol>
ТӨӨЗ 2.1	<p><b>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь:</b> Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгээ Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">\ www.tender.gov.mn \</a> хаягаар өөрийн ААН- ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ.</p> <p><b>Тендер хүлээн авах этгээд:</b> Хэнтий аймгийн Дархан сум ЕБС</p> <p><b>Байгууллагын хаяг:</b> [Хэнтий аймаг Дархан сум ЕБС ]</p> <p><b>Давхар болон өрөөний дугаар:</b> [ЕБС-ийн байр 2 давхар 211 тоот өрөө ]</p> <p><b>Аймаг, хот:</b> Хэнтий аймаг Дархан сум</p> <p><b>Тендер хүлээн авах эцсийн хугацаа:</b> Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> -ийн серверийн цагаар тооцогдох тул тендер хүлээн авах хугацаанаас хоцорсон тендерийн материал хүлээн авах</p>

	<p>боломжгүй.</p> <p><i>Огноо: [2024 оны 03 дүгээр сарын 15-ний өдөр]</i></p> <p><i>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: [2024 оны 03 дүгээр сарын 15-ны өдөр 10 цаг 00 минут хүртэл]</i></p>
ТӨӨЗ 2.1	<p><i>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</i></p> <p><i>Байгууллагын хаяг: [Дархан сумын ЕБС]</i></p> <p><i>Давхар болон өрөөний дугаар: [ЕБС-ийн байр, 2 давхар, 211 тоот өрөө]</i></p> <p><i>Огноо: [2024 оны 03 дүгээр сарын 15-ны өдөр]</i></p> <p><i>Цаг: [10 цаг 30 минут нээнэ.]</i></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар ЕБС-ИЙН ҮДИЙН ЦАЙ, ХЭАДСЕБС/20240202002</p>

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ Техникийн тодорхойлолтын хураангуй.

Нийлүүлэх болон холбогдох үйлчилгээнд дор дурьдсан техникийн тодорхойлолт стандартад нийцсэн байна.

Нэр төрлийн дугаар	бараа болон холбогдох чилгээний нэр	Техникийн тодорхойлолт болон стандарт
Багц 1	Мах махан бүтээгдэхүүний багц (үхэр, хонь)	<p>Нийлүүлэгдэх мах нь стандартын шаардлага хангасан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Мах нь шинэ чийгээ алдаагүй, технологийн дагуу цэвэрлэж, хөлдөөсөн, гадаргуу цэвэр, гадны үнэр, амт байхгүй байна. (шивтэр, бензин гэх мэт, хэвлийн хөндийд дайвар бүтээгдэхүүн болон махны ялгадасгүй байх)</li> <li>• 1-р зэргийн үхэр, хонины зөөлөн, шүүслэг мах байна.</li> <li>• Үйлдвэрлэгдсэн он сар өдөр, хадгалах хугацааг сав баглаан дээр тодорхой заасан байна.</li> <li>• Лабораторийн шинжилгээний бичиг болон гарал үүслийн бичигтэй байна.</li> <li>• Шаардлагатай тохиолдолд захиалагч байгууллага шинжилгээнд давтан оруулсан тохиолдолд шинжилгээний төлбөрийг нийлүүлэгч тал хариуцах (төлбөр төлөх)</li> <li>• Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиудыг хэрэгжүүлсэн байна.</li> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар хүргэж ирнэ.</li> <li>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгсэлийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.</li> </ul>

<p><b>Багц 2</b></p>	<p><b>Сүү сүүн бүтээгдэхүүний багц</b></p>	<p><b>Ерөнхий зүйл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийлүүлэгдэх сүү, сүүн бүтээгдэхүүн нь стандартын шаардлага хангасан байна.</li> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж</li> <li>• ирнэ.</li> <li>• Зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</li> <li>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.</li> <li>• Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиудыг хэрэгжүүлсэн байна.</li> <li>• Лаборторийн шинжилгээний болон гарал үүслийн бичигтэй</li> <li>• байна.</li> <li>• Нийлүүлэгдэх сүү сүүн бүтээгдэхүүн нь эх орны бүтээгдэхүүн байна.</li> <li>• Барааны нэр: Аарц:</li> <li>• Монгол аргаар бэлтгэгдсэн, стандартын шаардлагахангасан</li> <li>• байна. /хог хаягдал, шавьж хорхойгүй/</li> <li>• Цагаан өнгөтэй.</li> <li>• Хэт исгэлэн гашуун, ахарсан, хөгцөрсөн биш байна.</li> <li>• Аарц нь 30кг-аар дээшгүйгээр савлагдсан хөлдүү байна.</li> <li>• <b>Барааны нэр: Пакеттай сүү:</b></li> <li>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</li> <li>• 1л савалгаатай шингэн сүү байна.</li> <li>• Тээвэрлэлтийн гормыг баримтлана.</li> <li>• Зориулалтын сав баглаанд савласан байна. (сав нь гэмтэж хагараагүй байх)</li> <li>• Тухайн багцад шалгарсан ААНэгж нь гэрээнд заасан заалтаас буцсан тохиолдолд гэрээг цуцалж хар</li> </ul>
----------------------	--	---



<p><b>Багц 3</b></p>	<p><b>Хүнсний ногооны багц</b></p>	<p><b>Ерөнхий зүйл:</b>  Нийлүүлэгдэх ногоо нь орон нутагт тариалагдсан, стандартын шаардлага хангасан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар хүргэж ирнэ.</li> <li>• Хорхойнд идэгдээгүй байх</li> <li>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.</li> <li>• Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиудыг хэрэгжүүлсэн байна.</li> <li>• Лаборторийн шинжилгээний болон гарал үүслийн бичигтэй байна.</li> </ul> <p><b>2.1 Барааны нэр: Төмс</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Гэмтэж муудаагүй, зөөлрөөгүй, соёолоогүй, хайрагдаагүй, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна.\гадаргууд нь шороо чулуу наалдаагүй байх\</li> <li>• Стардартын шаардлага хангасан үрээр тарьсан байх.\Хятад үрийн төмсөөр тариагүй байх\</li> </ul> <p><b>2.2 Барааны нэр: Байцаа</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Байцаа нь нягтрал сайтай, муудаж гэмтээгүй гадны үнэр амтгүй,ялзраагүй байх.</li> <li>• Байцааны дундаж жин нь 2-2.5кг байх</li> <li>• Гадаргууны илүүдэл навч, голыг цэвэрлэсэн байна.</li> </ul> <p><b>Барааны нэр: Бөөрөнхий сонгино</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Ялзарч муудаагүй,хатаж чийгээ алдаагүй, ааг амтсайтай, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна.</li> <li>• Орон нутагт тариалсан байна.</li> <li>• Соёлж, хөгшрөөгүй байхаас гадна 1ш сонгины дундаж жин 100-150гр байх.</li> </ul> <ul style="list-style-type: none"> <li>• 100кг сонгино бүрт 2 кг хорогдол тооцож байх</li> </ul> <p><b>2.3 Барааны нэр: Лууван</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• 1 ш луувангийн дундаж жин 200-300 гр байх ба механик элдэв хольцгүй,зөөлөрч муудаагүй,чийгээ алдаагүй соёолоогүй,гадны үнэр амтгүй байна.</li> <li>• Лууванд агуулагдах коратин болон бусад төрлийн аминдэм нь алдагдаагүй, багавтар чихэрлэг амттай улбар шар өнгөтэй байна.</li> <li>• 100кг лууван бүрт 2 кг хорогдол тооцож түүнтэй тэнцэх хэмжээний лууван нэмж олгоно.</li> </ul> <p><b>2.4 Барааны нэр: Манжин</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Шар, хүрэн манжин нь стандартын шаардлага хангасан байна.</li> <li>• Гэмтээгүй, ялзарч муудаагүй, хөгшрөөгүй,шинэ байна.</li> <li>• Гадаргууны шороо, үндэс, навчыг бүрэн цэвэрлэсэн байх</li> <li>• Тухайн багцад шалгарсан ААНэгж нь гэрээнд заасан заалтаас буцсан тохиолдолд гэрээг цуцалж хар жагсаалтанд оруулах хүртэлх арга хэмжээг тооцно.</li> </ul>
----------------------	------------------------------------	--

<p><b>Багц 4</b></p>	<p><b>Гурил, Гурилан бүтээгдэхүүн</b></p>	<p>Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирнэ.</li> <li>• Зориулалтын сав баглаанд савласан байна.</li> <li>• Зориулалтын тээврийн хэрэгсэлээр тээвэрлэнэ.</li> <li>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгсэлийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.</li> <li>• Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиудыг хэрэгжүүлсэн байна.</li> <li>• Нийлүүлэх нарийн боов нь тослог давхраат, өндгөн, хөөмөл, зуурмагаар бэлтгэгдсэн олон төрөл байна.</li> <li>• Хэлбэр дүрсээ алдаагүй, өнгө үзэмж сайтай шинэ байна.</li> </ul> <p>Хүүхдийн эрүүл мэндийг дэмжсэн эрүүл хүнс байна. (аминдэм, ккал нь стандартын норм хангасан) .</p> <ul style="list-style-type: none"> <li>•</li> </ul> <p><b>Барааны нэр: Мушгиа гоймон</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийлүүлэгдэх гоймон нь үйлдвэрийн аргаар боловсруулагдсан олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн байна.</li> <li>• 5кг-аар савлагдсан, чийг аваагүй хуурай, хөгцөрч муудаагүй, үүрч гэмтээгүй, хэлбэр дүрсээ алдаагүй, шинэ байна.</li> </ul> <p><b>Барааны нэр: Гурил</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• М^80244:2009 техникийн шаардлага хангасан байна.</li> <li>• Г адны механик хольцгүй ба үнэр амтгүй, хөгцөрч муудаагүй байна.</li> <li>• 1-р зэргийн тэмдэгтэй байна.</li> <li>• 25 -кг-аар савлагдсан,</li> <li>• Чийгээ алдаагүй, шинэ байна.</li> </ul> <p><b>Барааны нэр: Цайны пичень</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• 800 гр-аар савлагдсан Азжаргал цайны пиченьтэй дүйцэхүйц амт чанар сайтай байна.</li> <li>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</li> </ul> <p><b>Барааны нэр: Будааны төрөл (цагаан, шар, хүүхдийн будаа)</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• М^8 0142:1985 техникийн шаардлага хангасан байна.</li> <li>• Гадны механик хольцгүй ба үнэр амтгүй, бяцарч хуваагдаагүй байна. <ul style="list-style-type: none"> <li>• Цагаан будаа нь том ширхэгтэй, агшаахад нялцаахгүй байх</li> </ul> </li> <li>• <b>Тухайн багцад шалгарсан ААНэгж нь гэрээнд заасан заалтаас буцсан тохиолдолд гэрээг цуцалж хар жагсаалтанд оруулах хүртэлх арга хэмжээг тооцно.</b></li> </ul>
----------------------	---	---

Багц 5	<p style="text-align: center;"><b>Жимс, жимсгэнэ</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</li> <li>• Зориулалтын сав баглаанд савласан байна.</li> <li>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. ( элдэв өнгө амт үнэргүй, хатаж хорчийгоогүй, хөгцгүй, шороо чулуугүй, хог хаягдалгүй дээд зэргийн чанарынх байна)</li> <li>• Шинэ жимс нь исээгүй , няцраагүй, хорхой идээгүй, хөгцрөөгүй, иш, навчгүй байна.</li> </ul> <p><b>Барааны нэр: алим</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Стандартын шаардлага хангасан амт чанар сайтай байна</li> <li>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. ( элдэв өнгө амт үнэргүй, чийгээ алдаагүй, хөгцгүй байна)</li> </ul> <p><b>Барааны нэр: Чацаргана</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• <b>0,5 л-ийн савалгаатай эрүүл ахуйн шаардлага хангасан өтгөрүүлсэн жүүс байна</b></li> <li>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</li> <li>• <b>Тухайн багцад шалгарсан ААНэгж нь гэрээнд заасан заалтаас буцсан тохиолдолд гэрээг цуцалж хар жагсаалтанд оруулах хүртэлх арга хэмжээг тооцно.</b></li> </ul>
--------	--	---

<p><b>Багц 6</b></p>	<p><b>Бусад хүнсний багц</b></p>	<p><b>Ерөнхий зүйл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</li> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирнэ.</li> <li>• Зориулалтын сав, баглаанд савласан байна.</li> <li>• Зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</li> <li>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.</li> <li>• Хүнсний хуулийг хэрэгжүүлсэн байна.</li> <li>• Хадгалалтын хугацаа дуусаагүй бүтээгдэхүүнбайх</li> <li>• Лабораторийн шинжилгээний бичигтэй байна.</li> </ul> <p><b>Барааны нэр: Элсэн чихэр</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• М<sup>80244</sup>:1999 техникийн шаардлага хангасан байна.</li> <li>• Г адны үнэр амтгүй, механик хольцгүй байна.</li> <li>• Чийг аваагүй хуурай, бөөгнөрч хатуураагүй, шарлаагүй байна.</li> </ul> <p><b>Барааны нэр: Давс</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• 1 кг-аар савлагдсан, чийг аваагүй хуурай, бөөгнөрч хатуураагүй, иодын агууламж нь зохих түвшинд байна.</li> </ul> <p><b>Барааны нэр: Масло</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</li> <li>• Зориулалтын сав баглаанд савласан байна.</li> <li>• Тослогийн хэмжээ 82 %-аас багагүй байна.</li> <li>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. (хайлаагүй, хөгцгүй, элдэв өнгө амт үнэргүй байна)</li> </ul> <p><b>Барааны нэр: Ургамлын тос</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• 1л-ээр савлагдсан 8иппу доМ-той дүйцэхүйц чанартай, Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</li> <li>• Зориулалтын сав баглаанд савласан байна.</li> <li>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. ( элдэв өнгө амт үнэргүй байна)</li> </ul> <p><b>Барааны нэр Варень</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• 850-860 гр-аар савлагдсан Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</li> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж</li> </ul>
----------------------	----------------------------------	--

		<p>ирнэ.</p> <ul style="list-style-type: none"><li>• Зориулалтын сав баглаанд савласан байна. (сав нь гэмтэж хагараагүй байх)</li><li>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. ( элдэв өнгө амт үнэргүй, усжаагүй, хөгцгүй байна)</li></ul> <p><b>Барааны нэр: Хуурай цай</b> ( 30 ширхэгтэй, пакеттай)</p> <ul style="list-style-type: none"><li>• Их тайгатай дүйцэхүйц чанартай, Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</li><li>• Зориулалтын сав баглаанд савласан байна.</li><li>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байна.</li><li>• <b>Тухайн багцад шалгарсан ААНэгж нь гэрээнд заасан заалтаас буцсан тохиолдолд гэрээг цуцалж хар жагсаалтанд оруулах хүртэлх арга хэмжээг тооцно.</b></li></ul>
--	--	--

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат хугацаа *[тоо]* жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш *[ГТН-д заасан тоо]* хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-ээс гэрээг цуцлах 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.

- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

### Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН - 1)**
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН - 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болонтээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаатзасварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- 6) Багц тус бүрт нийлүүлэгчээр шалгарсан ААНэгж нь тендерийн баримт бичигт заасан техникийн тодорхойлолт болон үнийн саналын маягтын дагуу шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг нийлүүлээгүй болон үнийн дүнд өөрчлөлт орсон тохиолдолд гэрээг цуцлаж, хар жагсаалтанд оруулах арга хэмжээг тооцно.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН - 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн  $[100]^1$  хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup>**
- 9.1. Алданги оногдуулах хувь:  $[0,5]$

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_ -аас оны дугаар сарын \_\_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;

Үнийн санал;

Гэрээний тусгай нөхцөл;

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.



Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

## Тав. Үнийн саналын маягт

### Хэнтий аймгийн Дархан сумын ЕБС-ийн Үдийн цайны хүнсэнд хэрэглэгдэх орцын норм

1. Бид, [..... ХХК] дор дурдсан барааг  
 ...../тоо/ ..... /Үсгээр/

төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу нийлүүлэхээр санал болгож байна.

2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.

3. Бид гэрээний Ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

2024.03.05.

<b>Багц - 1 Мах махан бүтээгдэхүүн-13,500,000</b>														Санал
Д / Д	Бүтээгдэхүүн ий нэр	Хэжих нэгж	Сард хэрэглэх орц	1	2	3	4	5	9	10	11	12	Жилд хэрэглэх нийт хэмжээ	
1	Үхрийн мах	кг	0.240										1350	
2	Хонины мах	кг	0.240											
<b>Багц - 2 Сүү сүүн бүтээгдэхүүн-7,050,000</b>														
1	Сүү 1 литрын савалгаатай пакеттай сүү	л	0.400										900	
2	Аарц	л	0.400										300	
<b>Багц - 3 Хүнсний ногоо-5,455,000</b>														
1	Төмс	кг	0.240										1091	
2	Байцаа	кг	0.240											
3	Лууван	кг	0.240											
4	Сонгино	кг	0.240											
5	Шар манжин	кг	0,240											
6	Хүрэн манжин	кг	0,240											
<b>Багц - 4 Гурилан бүтээгдэхүүн-10,447,000</b>														

1	Гурил /25кг/	25кг	0.105											300			
2	Цайны Печень /800гр/	ш	0.050											650			
3	Гурвалжин будаа	кг	0.050											230			
4	Хөц будаа	кг															
5	Цагаан будаа	кг															
6	Шар будаа	кг															
7	Хүүхдийн Будаа /1кг/	кг	0.050											45			
8	Хөөмөл боов	кг	0.050											50			
9	Саран боов /2,5кг/	2,5кг	0.050											350			
10	Лашша гоймон	5кг	0.050											85			
11	Мушгиа гоймон /5кг/	5кг															

**Багц - 5 Жимс жимсгэнэ-4,992,000**

1	Алим	кг												510	
2	Чацаргана /0,45л-0,48л/	ш												114	

**Багц - 6 Хуурай хүнс-1,793,800**

1	Элсэн чихэр	кг	0.60											75	
2	Масло	кг	0.015											18	
3	Ургамлын тос /1л/	л												100	
4	Цай /30ш савалгаатай/	ш												22	
5	Давс /1кг/	ш	0.010											34	

Баталгаат хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг: